

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2025/033/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2025 он

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг:

enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Д.Даариймаа

Утас: 70342495 Цахим хаяг:

daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2024.02.03 № 29
танай _____ ны № _____ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНХӨЛӨГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг энцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 15.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хөрөнгийн дахин үнэлгээнээс 1,189.9 сая төгрөгийн үнэ шинэчлэн тогтоож нийт 2,370.6 сая төгрөгөөр хөрөнгийн орлогын хөдөлгөөн хийгдсэн байна

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь өмнөх онтой хариуцуулахад цалингийн зардал 229.9 сая төгрөгөөр өссөн нь цалингийн шатлал нэмэгдсэнээс шалтгаалж байна.

632502036

Бусад асуудлын хэсэг

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 зорилт 20 арга хэмжээний хэрэгжилт 88.6 хувиар дүгнэсэн, хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,039.6 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 95.6 хувийг зарцуулсан байна.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулсаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бид, бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮЯ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	172,731,426.24	280,023,423.74
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,066,095,605.49	2,385,850,879.67
Нийт хөрөнгийн дүн	2,238,827,031.73	2,665,874,303.41
Нийт өр төлбөрийн дүн	-	0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,238,827,031.73	2,665,874,303.41
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,238,827,031.73	2,665,874,303.41
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,170,137,937.00	1,776,447,756.90
Үйл ажиллагааны зардлын дүн	1,129,920,851.96	1,350,590,484.74
Үйл ажиллагааны үр дүн	1,040,217,085.04	425,857,272.16
Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,034,048,508.51	425,857,272.16
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		2,238,827,031.73
Тайлант оны үр дүн		425,857,272.16
Эцсийн үлдэгдэл		2,665,874,303.41
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	881,020,837.00	1,147,801,246.43
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	876,740,937.00	1,132,192,246.43
Үйл ажиллагааны ЦМГ	4,279,900.00	15,609,000.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4,279,900.00)	(15,609,000.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,039,590,500.00	994,556,373.61
Урсгал зардал	1,039,590,500.00	978,947,373.61
Хөрөнгийн зардал	-	15,609,000.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	994,590,500.00	964,223,400.00
Улсын төсвөөс санхүүжих	994,590,500.00	962,040,400.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	2,183,000.00

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төр засгийн бодлого шийдвэрийг хуулийн хүрээнд бүтээлчээр хэрэгжүүлж, иргэдийн эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг шударга, ёс зүйтэй, ил тод, хөнгөн шуурхай хүргэхэд оршино.

Зорилго: Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, иргэдийнхээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Зорилт: Засаг даргын тамгын газрын мэдлэг чадварт суурилж, хамтын үйл ажиллагаанд тулгуурлан нэг зорилгийн төлөө идэвхи санаачлагатайгаар эрч хүчтэй, бүтээлч сэтгэлгээтэй, эвсэг хамт олон хөгжлийн хөтөч уриатайгаар төрийн захиргаа, цагдаагийн хэсэг, мал эмнэлэг үржлийн тасаг, санхүүгийн алба, байгаль орчны хэсэг, нэг цонхны үйлчилгээ, төрийн үйлчилгээний болон гэрээт ажилчид гэсэн нэгж хэсгүүдтэйгээр төрийн албаны ёс зүйг чанд хэрэгжүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэнэ.

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлууд

Шишиг-Өндөр сумын ЗДТГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,291.9 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

Тав. Аудитын гол асуудал

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 824.4 сая төгрөгөөр нийт зарлагыг 824.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс төслийн саналын дүнгээр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,007.0 сая төгрөгийг төсвөөс авсан байна.

Гүйцэтгэлээр улс орон нутгаас 1,147.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж 1,083.5 сая төгрөгийг зарцуулан 64.3 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулиар цахим хуудсанд мэдээлэхээр заасан мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээний 58,045.7, зарлагын 20 гүйлгээний 220,694.2 мянган мэдээллийг байршуулаагүй, мөн өмч хөрөнгөтэй холбоотой 18 тушаал шийдвэр мэдээлсэн байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Найм. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,600.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,600.0 мянган төгрөгийн 2 Төлбөрийн акт оногдуулан ажиллаа.

8.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд нэг албан хаагчийн цалингийн урьдчилгааг суутгаагүй 600.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

2. Тайлант онд тэмдэглэлт ойтой Дашинчилэн, Хутаг-Өндөр, Бугат, Хангал суманд нийт 3,000.0 мянган төгрөгийг хандивласан байна.

8.2 Албан шаардлага Байхгүй

8.3 Зөвлөмж Байхгүй

